



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН

**Захиалагч: Хууль зүй, дотоод хэргийн яам
Гүйцэтгэгч: Судлаач Э.Мөнхдаваа**

Улаанбаатар 2018 он

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн хэрэгжилтэд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлгээг хийлээ.

Үнэлгээг дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлөвлөх үе шат
2. Хэрэгжүүлэх үе шат
3. Үнэлэх үе шат

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлсэн болно.

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох
4. Харьцуулах хэлбэрийг сонгох
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох
6. Мэдээлэл цуглуулах арга сонгох

1.1 Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д хуулийн зүйл, заалтын уялдаа холбоог сайжруулах, нэр томьёог нэг мөр болгох, цаг үеийн шаардлагад нийцүүлэн зохицуулалтыг шинэчлэх зорилгоор Шүүхийн шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар тусгасан байна.

Шүүхийн шинжилгээний тухай хууль нь 2009 оны 12 сарын 3-ны өдөр батлагдсан бөгөөд 2015 онд 1, 2016 онд 2, 2017 онд 2 нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Шүүхийн шинжилгээний байгууллага гэмт хэрэгтэй тэмцэх, нотлон тогтоох ажилд хуулиар хүлээсэн үүргийн дагуу хувь нэмрээ оруулсаар ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд шүүхийн шинжилгээтэй холбоотой тулгамдаж буй асуудлууд, тухайлбал шинжилгээний чанар, стандарт, хугацаа, бүртгэл, лавлагаа, объектын бүрэн бүтэн байдалд анхаарал хандуулсны хүчинд мэдэгдэхүйц ахиц гаргасан байна. Гэвч эрх зүйн зохицуулалт, байгууллагуудын уялдаа холбоо, бүтэц, зохион байгуулалт, сургалт, хүний нөөц буюу гадаад хүчин зүйлээс хамаарсан тулгамдсан асуудлууд байсаар байна.

Эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид заасан тусгай мэдлэг шаардсан асуудлыг шийдвэрлэхийн тулд шинжилгээний объектод

шинжилгээ хийж дүгнэлт гаргах ажиллагаа хараат бус, хүний эрх эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах, тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэстэй хийх боломжийг уг хуулиар хангаж чадах байгаа эсэх, ийнхүү хангах боломжийг бүрдүүлж чадаж байгаа эсэхийг тогтоож, дүгнэлт гаргах, түүнчлэн манай улсад үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэж, эрүүгийн нөхцөл байдал, нийгмийн харилцаанд гарсан өөрчлөлтөөс шалтгаалан тухайн хуулийн зарим заалтыг нарийвчлан тодорхойлж хуулинд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг тогтоох зорилготой.

Иймээс 2009 оноос эхлэн мөрдөгдөж ирсэн тус хуулийн зохицуулалт нь зорилгодоо хүрсэн түвшинг тогтоох, цаашдын үр дагавар, хүлээн зөвшөөрөгдөх байдал, практикт хэрэгжих боломж болон бусад дагалдах үр дагаварыг илрүүлэх, хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгах, түүний хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх, гарч буй хүндрэл бэрхшээлтэй асуудлууд, нийгэмд үзүүлж буй эерэг болон сөрөг нөлөөллийг илрүүлэх, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжих, хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлох зорилгоор тус хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлагатай гэж үзлээ.

1.2. Үнэлгээний хүрээг тогтоох

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн үнэлэгдэх шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

д/д	Үнэлэгдэх зүйл	Үнэлэгдэх хэсэг, заалт
1	4 дүгээр зүйл 14 дүгээр зүйл	4.1.3.Хараат бус байх зарчим 14.1.7.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон бусад этгээдээс хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах;
2	37 дугаар зүйл.Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо	37.1.Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн. 37.2.Шүүхийн шинжилгээний байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана. 37.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ. 37.4.Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно.
3	43 дугаар зүйл.Шүүх шинжилгээний байгууллагын	43.1.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана. 43.2.Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан

ажилтны эрх зүйн баталгаа	1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно. 43.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна. 43.4.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно. 43.5.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.
---------------------------	--

1.2.Шалгуур үзүүлэлтийг тогтоох

Өмнөх үе шатанд үнэлгээ хийхээр сонгосон Шүүхийн шинжилгээний тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн байдлыг тогтооход туслах Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг бодитоор илэрхийлж гаргаж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзуулан сонгов.

Хүснэгт 2

Д/д	Үнэлэгдэх зүйл	Үнэлэгдэх хэсэг, заалт	Шалгуур үзүүлэлт
1	4 дүгээр зүйл 14 дүгээр зүйл	4.1.3.Хараат бус байх зарчим 14.1.7.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон бусад этгээдээс хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах;	Практикт нийцэж буй байдал, Зорилгодоо хүрсэн түвшин
2	37 дугаар зүйл.Шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо	37.1.Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн. 37.2.Шүүхийн шинжилгээний байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана. 37.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ. 37.4.Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно.	Практикт нийцэж буй байдал, Хүлээн зөвшөөрөгдсөн байдал
3	43 дугаар зүйл.Шүүх	43.1.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал, Зорилгодоо хүрсэн түвшин

шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгаа	баталгаагаар хангагдана. 43.2.Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно. 43.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна. 43.4.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно. 43.5.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.	
--	--	--

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, заалтын хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх боломжтой гэсэн шалгуураар сонгосон бөгөөд тухайн хуулийн зохицуулалтад төдий л ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох

Үнэлгээ хийхэд хуулийн үр дагаварын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрт тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээг хийх болно.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4, 14, 37, 43 дугаар зүйлийн холбогдох хэсэг, заалтыг зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг үнэлэхдээ хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгыг хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно. Үүнийг харьцуулах тоо баримт нь хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, статистик байна.

Шүүх шинжилгээний тухай хуулийн 4, 14, 37, 43 дугаар зүйлийн практикт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс өмнөх болон дараа, байх ёстой болон байгаа гэсэн харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтооно.

Хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

Хүснэгт 3

Д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр
1	4.1.3.Хараат бус байх зарчим 14.1.7.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон бусад этгээдээс хараат бус байж, гагцхүү хуульд захирагдах;	Практик нийцэж буй байдал Зорилгодоо хүрсэн түвшин	Байх ёстой ба одоо байгаа түвшин
2	37.1.Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн. 37.2.Шүүхийн шинжилгээний байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана. 37.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ. 37.4.Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно.	Практикт нийцэж буй байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Байх ёстой ба одоо байгаа түвшин Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш

3	43.1.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана.	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш
	43.2.Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно.	Зорилгодоо хүрсэн түвшин	
	43.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.		
	43.4.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно.		
	43.5.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.		

1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн алхмууд нь томьёолсон шалгуур үзүүлтэд хариулт өгөх замаар хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд чиглэгдэнэ.

Хүснэгт 4

д/д	Үнэлгээний хүрээ	Шалгуур үзүүлэлт	Харьцуулах хэлбэр	Шалгуур үзүүлэлтийн томьёолол
1	4.1.3.Хараат бус байх зарчим 14.1.7.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон бусад этгээдээс хараат бус байж, гагцхүү хуульд	Практикт нийцэж буй байдал Зорилгодоо хүрсэн түвшин	Байх ёстой ба одоо байгаа түвшин	Шүүхийн шинжилгээний байгууллага хараат бусаар ажиллаж чадаж байна уу? Уг хууль батлагдснаар хуулиар тавьсан зорилгод хүрсэн үү?

	захирагдах;			
2	37.1.Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн. 37.2.Шүүхийн шинжилгээний байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана. 37.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ. 37.4.Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно.	Практикт нийцэж буй байдал Хүлээн зөвшөөрөгдсөн байдал	Байх ёстой ба одоо байгаа түвшин Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Шүүхийн шинжилгээний байгууллага хуульд заасан чиг үүргээ, хуульд заасан шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж чадаж буй эсэх? Уг байгууллагын эрх, үүргийн хуульд оновчтой томьёолж чадсан уу? Хамаарал бүхий бусад этгээдүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үү? Уг зарчмаар ажил үүргээ гүйцэтгэхэд оновчтой эсэх? Энэ нь манай орны онцлог, гадаад улсын тэргүүн туршлагад нийцэж чадсан эсэх?
3	43.1.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана. 43.2.Шүүхийн			Хуулийн уг зохицуулалт нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг олгож буй эсэх? Хуулийн уг зохицуулалт нь албан хаагчид ямар бодит дэмжлэг болсон вэ?

шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно. 43.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна. 43.4.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно. 43.5.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.	Хүлээн зөвшөөрөгдсөн байдал Зорилгодоо хүрсэн түвшин	Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Хуулийн уг зохицуулалт нь хуулиар тавьсан зорилгыг хангасан эсэх? Уг зохицуулалт нь оновчтой, хараат бусаар ажиллахад бодит дэмжлэг болж чадсан уу? Хөндлөнгөөс оролцох, шахалт үзүүлэх нөхцөл байдал үүсч байгаа эсэх? Нөхцөл байдал үүссэн тохиолдолд уг заалт нь бодит хамгаалалт болж чадаж байна уу? Уг заалт нь оновчтой эсэх? Албан хаагчид хүлээн зөвшөөрсөн үү?
---	--	--	--

1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Төлөвлөлтийн үе шатанд хийгдсэн өмнөх алхам /үнэлгээний шалтгаан, хүрээг тогтоох, шалгуур үзүүлэлтийг сонгох, харьцуулах хэлбэрийг тогтоох, шалгуур үзүүлэлтийг томьёолох/-уудаа ямар тохиодолд тоон, ямар тохиолдолд чанарын мэдээллийг ямар аргаар цуглуулахаа энэ үе шатанд сонгоно.

Шүүх шинжилгээний хуулийн 4, 14, 37, 43 дугаар зүйлд үнэлгээ хийхдээ мэдээлэл цуглуулах дараахь аргыг ашиглана. Үүнд:

- Шүүх шинжилгээний харилцаанд оролцогч төрийн эрх бүхий байгууллагуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах
- Дээрх байгууллагуудын тайлан, статистик мэдээллийг ашиглах
- Тодорхой тохиолдол судлах, шүүхийн шийдвэр байгаа эсэхийг нягтлах, байгаа тохиолдолд тэдгээрийг судлах замаар үнэлгээ хийхэд ашиглах холбогдох чанарын болон тоон мэдээллийг цуглуулна.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2018 оны 07 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 23-ны өдрийн хооронд хэрэгжүүлэх үе шатыг хийж гүйцэтгэв. Энэ үе шатанд холбогдох төрийн байгууллагын тайлан мэдээтэй танилцах, шүүхийн шийдвэр судлах, судалгааны бүтээлийг судлах зэрэг аргаар судалж Шүүх шинжилгээний тухай хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулав.

ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд Шүүх шинжилгээний тухай хуулиас үнэлэхээр сонгож авсан холбогдох зүйл, заалтыг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлэх болно.

3.1.Шүүх шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3

Хүснэгт 5

Үнэлэгдэх хэсэг	4.1.3.Хараат бус байх зарчим
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	Шүүх шинжилгээний байгууллага хараат бусаар ажиллаж чадаж байна уу? Уг хууль батлагдснаар хуулиар тавьсан зорилгод хүрсэн үү?

Үнэлгээ: Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны хараат бус байдлыг хангах тухай зохицуулалтыг Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт “шүүхийн шинжилгээ хийхэд хараат бус байх зарчмыг баримтална”, 43 дугаар зүйлийн 43.4 дэх хэсэгт “шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно.” гэх зэргээр баталгаажуулж өгсөн. Энэ нь шинжээчийн шинжилгээ хийх явцад хараат бусаар ажиллахад чухал ач холбогдолтой болсон боловч практикт шинжээчийн хараат бус байдал зарим талаар хангагдахгүй байна гэж үзжээ. Тухайлбал, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн ажилтнуудаас авсан социологийн судалгаагаар шинжээчид прокурор, мөрдөгч, мөн зарим тохиолдолд дээд шатны удирдлагаас нөлөөлж болзошгүй байдал гардаг гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд шинжээчийн үйл ажиллагааны хараат бус байдлыг хангахдаа эдгээр субъектын эрх, үүрэг, хариуцлагыг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт “Прокурор, мөрдөгч нь өөрийн санаачилгаар, эсхүл оролцогчийн хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд тусгай мэдлэг зайлшгүй шаардагдах асуудлыг тодруулахаар, эсхүл эд зүйл, хөрөнгийн үнэлгээ тогтоох шинжилгээ хийлгэхээр шинжээч томилно.”, 9.1 дүгээр зүйлийн 9.1.5 дахь хэсэгт “Шинжээч гаргасан дүгнэлттэй холбоотой асуудлаар шүүх, прокурор, мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирж мэдүүлэг өгнө.” гэж тусгасан. Иймд хуулийн энэхүү зохицуулалттай холбоотойгоор хараат бус байдлыг хангах, урьдчилан сэргийлэх

шаардлагатай гэж үзжээ.

Түүнчлэн шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчдын үйл ажиллагааны хараат бус байдалд халдсан тохиолдолд хүлээлгэх хуулийн хариуцлага Шүүхийн шинжилгээний тухай хууль болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой бус байгаа нь шинжээчид хууль бусаар нөлөөлөх байдал гарч болзошгүй. Иймээс Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн 21.6.1 дэх хэсэгт "Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ." гэсэн хэсэгт нэмэлт, өөрчлөлт оруулж, энэ зүйлд шинжээчийг нэмж тусгах шаардлагатай. Ийнхүү тус заалтад шинжээчийг тусгаагүй нь хараат бус байдалд тодорхой хэмжээгээр нөлөөлж болзошгүй байна.

3.2.Шүүх шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйл

Хүснэгт 6

Үнэлэгдэх хэсэг	37.1.Шүүхийн шинжилгээний байгууллага нь эрүү, иргэн, захиргааны болон бусад хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нотлох баримтыг илрүүлж бэхжүүлж авах, ул мөр, эд мөрийн баримтад үзлэг, шинжилгээ хийж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн. 37.2.Шүүхийн шинжилгээний байгууллага нь нутаг дэвсгэрийн болон ажил үүргийн зарчмаар зохион байгуулагдана. 37.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ. 37.4.Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно.
Томьёологдсон шалгуур үзүүлэлт	Шүүх шинжилгээний байгууллагад хуульд заасан чиг үүргээ, хуульд заасан шаардлагад нийцүүлэн гүйцэтгэж чадаж буй эсэх? Уг байгууллагын эрх, үүргийн хуульд оновчтой томьёолж чадсан уу? Хамаарал бүхий бусад этгээдүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үү? Уг зарчмаар ажил үүргээ гүйцэтгэхэд оновчтой эсэх? Энэ нь манай орны онцлог, гадаад улсын тэргүүн туршлагад нийцэж чадсан эсэх?

Үнэлгээ: Энэ ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 63 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн яамны харьяа Шүүх эмнэлгийн магадлах төв, Сангийн сайдын дэргэдэх Шүүх нягтлан бодох

бүртгэлийн магадлах товчоо, Цагдаагийн ерөнхий газрын Криминалистикийн шинжилгээний хүрээлэнг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Шүүхийн шинжилгээний үндэсний төвийг байгуулсан.

Засгийн газрын 2007 оны 270 дугаар тогтоолын дагуу Аймаг, нийслэлийн цагдаагийн газар, хэлтсийн криминалистикийн шинжээч, нэгдсэн эмнэлгийн эмч нарыг нэгтгэн “Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний алба”-ыг байгуулсан. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 1 дүгээр сарын 21 -ний өдрийн 19 дүгээр тогтоолд заасны дагуу тус байгууллагыг “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн” болгож үйл ажиллагааг өргөжүүлсэн. Үүний дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар”-ыг шинэчлэн баталсан. Үүнд:

- Захиргаа, удирдлагын газар;
- Санхүү төлөвлөлт, хангамжийн газар;
- Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс;
- Криминалистикийн шинжилгээний газар;
- Шүүх эмнэлгийн шинжилгээний газар;
- Тусгай шинжилгээний газар;
- Эдийн засгийн шинжилгээний хэлтэс;
- Шинжилгээний бүртгэл, мэдээллийн хэлтэс;
- Аймаг, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар, алба, тасаг, хэсэг” гэсэн бүтэцтэй буюу 6 газар, 3 хэлтэс, 7 тасаг, 22 алба, 8 хэсэгтэй, 514 албан хаагчийн орон тоотой батлагджээ.

Шүүхийн шинжилгээний тухай хууль 2009 онд батлагдсанаас хойш нийтдээ таван удаа нэмэлт, өөрчлөлт орсон тухай дээр дурдсан. Эдгээр нэмэлт, өөрчлөлт нь тухайн хуулийн үзэл баримтлалыг тодотгосон шинжтэй болсон байна. Мөн шинээр батлагдсан хууль болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбоотойгоор уг хуулинд өөрчлөлт оруулж байжээ.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүхийн шинжилгээний төв байгууллага, аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албанаас бүрдэнэ.” гэж тусгасан. Үүнээс харахад энэхүү хуульд шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцооны талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, албан хаагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тусгаагүй бөгөөд энэхүү харилцааг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 82 дугаар тушаалаар батлагдсан “Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүрэм”-д зааснаар зохицуулж байна. Ялангуяа, шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, түүний эрх, үүрэг, хариуцлагыг хуульд нарийвчлан тусгаагүйгээс болж цаашид энэ байгууллагад улс төрийн нөлөөлөл бий болох, улмаар шинжилгээний байгууллагын хараат бус байдалд

сөрөг нөлөөлөл гарч болзошгүй.

Түүнчлэн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт "Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй байж болно." гэж тусгасан бөгөөд хуульд тусгасан эрдэм шинжилгээ, судалгааны чиг үүрэг бүхий нэгжийг байгуулаагүй байна. Үүнд олон хүчин зүйлс нөлөөлж байгаагийн дотор санхүү, төсвийн хүндрэлтэй байдал, эрдэм шинжилгээ, судалгаа хийх техник тоног төхөөрөмжийн хүрэлцээ муу зэрэг нөлөөлж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагын санхүүжилт, техник, технологийн асуудал:

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Шүүхийн шинжилгээний байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ" гэж тусгасан. Нийт төсвийн дийлэнх хувийг цалингийн зардал эзэлдэг бөгөөд тоног төхөөрөмжийн шинэчлэл, хөрөнгө оруулалт хийгдээгүй нь үндсэн чиг үүргээ биелүүлэхэд хангалтгүй байна. Тухайлбал, нийслэлийн төвд байрлаж байгаа шүүх эмнэлэгт улсын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн хохирогч нар ирж үзүүлдэг, нас барсан тохиолдол болгонд задлан шинжилгээ хийгддэг нь эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй байгаа тул шүүх эмнэлгийн задлан шинжилгээ болон цогцос хадгалах өрөө, зарим лабораторийг хотын захад шилжүүлэхэд анхаарах шаардлагатай.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс ирүүлсэн мэдээллээр 2017 оны байдлаар 8 аймаг өөрийн байртай бөгөөд бусад алба, хэсэг түрээсийн болон цагдаагийн газар, хэлтэстэй хамт нэг байранд ажиллаж байна. Ийнхүү орон нутгийн алба, хэсэг өөрийн байргүй байгаа асуудалд анхаарах шаардлагатай байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагаас ирүүлсэн мэдээллээр Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд шаардагдах төсөв батлагдахгүй байгаагаас:

- Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийг авч чадахгүйтэй холбоотой техник технологийн хоцрогдолд орж, зарим нэр төрлийн шинжилгээг хийж чадахгүй байх, эд мөрийн баримт үгүй болох, шинжилгээний дүгнэлт буруу гарах, албаны нууц задрах зэрэг эрсдэл гарч байна.
- Албаны байр болон зориулалтын лаборатори байхгүйгээс болж албан хаагчдыг эрүүл мэнд хохирч байна. Мөн үүнээс гадна нормын хувцас, хөдөлмөр хамгаалал, халдваргүйжүүлэлтийн хувцас хэрэгслийг хангаж чадахгүйгээс болж албан хаагчдын эрүүл мэнд эрсдэлд орж, халдварт өвчин авах эрсдэл үүсч байна.
- Авто машины шатахууны зардал хүрэлцдэггүй, жолоочийн орон тоо байдаггүй зэргээс шалтгаалж албаны шуурхай бэлэн байдал алдагдах нөхцөл бүрдсэн, мөн үүнтэй холбогдон шинжээч нарын ажлын ачаалал ихсэж байна.

- Дотоод албан томилолтын зардал дутуу батлагдсанаас болж албан хаагчид томилолтын хугацааны зардлаа бүрэн авч чадахгүй зохих хэсгийг хувиасаа гарган ажиллаж байна.
- Албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг давтан мэргэшил дээшлүүлж, хөгжүүлж чадахгүй, мөн өндөр ур чадвартай, нарийн мэргэжлээр төгссөн албан хаагчдыг орчин үеийн техник багаж, хэрэгслээр хангаж чадахгүй байна.
- Орон тооны хүрэлцээгүй байдлаас болж албан хаагчид өндөр ачаалалтай ажиллаж байна.

Техник, технологийг шинэчлэх, шинээр авч ашиглах олон асуудал тулгарч байна. Тэдгээрээс эн тэргүүнд шийдвэрлэх асуудал нь бидний судалгаагаар Шүүх эмнэлгийн шинжилгээнд буюу хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний явцад шаардлагатай болдог нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношлогоо, шаардлагатай техник хэрэгслийн (КТГ, MRI, Рентген, Тархины цахилгаан бичлэгийн төхөөрөмж, ЭХО, Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат гэх мэт) асуудал гэж үзэж байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтэст 2014 онд хийсэн хүний биед гэмтлийн зэрэг тогтоох 3000 шинжилгээнд судалгаа хийхэд 1706 шинжилгээнд нь гадны эмнэлэг, лабораторийн нарийн мэргэжлийн эмч, техник хэрэгслийн тусламжийг авсан байна. Энэ байдал нь шинжилгээ хийхэд хугацаа алдахаас гадна шинжээчийн дүгнэлтэнд ч буруугаар нөлөөлөхийг үгүйсгэхгүй юм.

3.3.Шүүх шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйл

Хүснэгт 7


Үнэлэгдэх хэсэг	✓ 43.1.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана. ✓ 43.2.Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно. ✓ 43.3.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна. 43.4.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны үйл ажиллагаанд шахалт үзүүлэх, хөндлөнгөөс оролцох, саад учруулах, заналхийлэхийг хориглоно. 43.5.Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтнаар хуулиар хүлээлгэсэн үүрэгт нь үл хамаарах ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.
Томъёологдсон шалгуур үзүүлэлт	Хуулийн уг зохицуулалт нь хуулиар хүлээсэн чиг үүргээ хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг олгож буй эсэх? Хуулийн уг зохицуулалт нь албан хаагчид ямар бодит дэмжлэг болсон вэ? Хуулийн уг зохицуулалт нь хуулиар тавьсан зорилгыг хангасан эсэх? Уг зохицуулалт нь оновчтой, хараат бусаар ажиллахад бодит дэмжлэг болж

	чадсан уу? Хөндлөгөөс оролцох, шахалт үзүүлэх нөхцөл байдал үүсч байгаа эсэх? Нөхцөлд байдал үүссэн тохиолдолд уг заалт нь бодит хамгаалалт болж чадаж байна уу?
--	---

Үнэлгээ: Хуулийн заалтыг хэрэгжүүлэх нь хууль сахиулагчдын үүрэг боловч хэргийн хугацаа, ажлын хэт ачааллаас болж аливаа хэрэг маргааныг бүрэн төгс шийдвэрлэж чадахгүй байгаа тал бүх хуулийн байгууллагуудын нийтлэг дүр төрх болсон байна. Энэ байдал нь эрх зүйн зохицуулалт, байгууллагын уялдаа холбоо, бүтэц зохион байгуулалтаас шалтгаалж байгаа боловч хүний нөөцийн бодлоготой шууд хамаатай асуудал гэж үзэж байна. Хэргийг гардаж мөрддөг, шийдвэрлэдэг, шинжилдэг албан хаагчдын тоо бага байгаагаас хэт ачаалалтай ажиллаж байна. Зарим төрлийн шинжилгээ, тухайлбал биологийн шинжилгээ гэхэд 1 шинжээч жилд 800 гаруй өдөрт 3,3 шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж байгаа байдал харагдаж байна. 2017 оны байдлаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнд 210, Нийслэлийн шүүхийн шинжилгээний албанд 91, аймгийн шүүхийн шинжилгээний албанд 203, нийт 504 албан хаагч, ажилтнууд ажиллаж байна. Эдгээр ажилтан, албан хаагчдын хувьд ажлын ачаалал харилцан адилгүй байдаг байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан нь Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албан хаагчийн баталгаагаар хангагдана.”, 43.2 дахь хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагад шинжээчээр ажилласан 1 жилийг 1 жил 2 сар ажилласанд тооцно.”, 43.3 дахь хэсэгт “Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны тэтгэвэр, тэтгэмжтэй холбогдсон харилцааг Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулиар зохицуулна.” гэж тусгасан. Үүнээс үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг хуульд зохих байдлаар тусгасан боловч байгууллагын ажилтан, албан хаагчийн ажиллах орчин нөхцөл, ажлын ачаалал өндөр байгаа зэрэг асуудал гарч байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд Монгол Улсад үйлдэгдэж байгаа зарим төрлийн гэмт хэргийн тоо өссөн, мөн шинэ төрлийн гэмт хэргүүдийн арга хэлбэр нарийссан зэрэгтэй холбоотойгоор шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчдын ачаалал тогтмол өсөж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагад 2017 онд 65525 шинжилгээ хийсэн байна. Нийт шинжилгээг чиглэлээр нь авч үзвэл 58,1 хувийг шүүх эмнэлгийн шинжилгээ, 21,4 хувийг хими, биологи, ДНХ, бактериологи, физикийн шинжилгээ, 20,1 хувийг криминалистикийн шинжилгээ, 0,3 хувийг эдийн засгийн шинжилгээ эзэлж байна. Үүнээс үзэхэд шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн нийт шинжилгээний 58.1 хувийг шүүх эмнэлэг дангаараа хийж байгаа нь тус салбарын эмч, шинжээчдийн хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.



Шүүхийн шинжилгээний статистик тайлан, 2017 он.

Шүүхийн шинжилгээний байгууллагад хийсэн шинжилгээний тоон үзүүлэлт /



Дээрх зургаас үзэхэд сүүлийн жилүүдэд шүүхийн шинжилгээний байгууллагын нийт шинжилгээний тоо буураагүй болох нь харагдаж байна. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчдын ажлын ачаалал, чиг үүргийн онцлогийг товч харуулбал:

Шүүх эмнэлгийн шинжилгээний газар

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар "Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар"-ыг шинэчлэн баталсан. Энэхүү журмын дагуу Шүүх эмнэлгийн шинжилгээний газар нь дараахь чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг хийж дүгнэлт гаргах;
- Цогцост задлан шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Хүний биеийн эд эсэд гистологийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах;

- Хавтаст хэргийн материалаар дүгнэлт гаргах;
- Эксгумаци (оршуулсан шарилд) шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Нэр хаяг тодорхойгүй, хариуцах эзэнгүй цогцос хадгалж, оршуулах;
- Шүүх эмнэлгийн чиглэлээр хийх шинжилгээ судалгааны ажилд дэмжлэг үзүүлж, зохион байгуулах;
- Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны шинжээч эмч нарыг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдний ур чадварыг ахиулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.

Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхдээ 2017 оны байдлаар нийт 49 (дарга 1, дэд дарга 1, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын чиглэлийн ахлах мэргэжилтэн 1, ахлах шинжээч 4, шинжээч эмч 21, гистологийн шинжээч 2, дүрс оношлогооны эмч 2, нарийн мэргэжлийн эмч 2, бага эмч 2, гистологийн лаборант 3, туслах ажилтан 8, угаагч 3) орон тоотой ажиллаж байна. Хөдөө орон нутгийн хувьд 21 аймгийн шүүхийн шинжилгээний албадад нийт 72 тооны шинжээч эмч, лаборант, туслах ажилтан ажиллаж байна.

Мөн тус газрын ирүүлсэн мэдээллээр сүүлийн жилүүдэд Шүүх эмнэлгийн шинжээч эмч нарын ажлын ачаалал нэмэгдэж, хийгдэж байгаа шинжилгээний тоон үзүүлэлт өссөн байна. Тухайлбал, Шүүх эмнэлгийн шинжилгээний газрын шинжилгээний тоон үзүүлэлтийг сүүлийн 8 жилээр харьцуулан харуулав.

Хүснэгт8

Хүний биед хийгдсэн шинжилгээ	
Он	тоо
2016	3018
2015	3147
2014	31535
2013	29370
2012	26249
2011	23183
2010	20835
2009	20746

Шинжээч эмчийн ажлын ачаалалтай харьцуулахад хүн амын суурьшил, нутаг дэвсгэрийн хэмжээ, зам харилцаа, гэмт хэргийн гаралт зэрэг олон хүчин зүйлээс хамаарч харилцан адилгүй байна. Мөн жилд дунджаар Шүүх эмнэлгийн шинжилгээний газарт цогцос шинжилгээ 80-85, хүний биед хийсэн шинжилгээ 600-650, хэргийн материалын шинжилгээ 100-120 хийдэг байна. Үүнээс үзэхэд Шүүх эмнэлгийн шинжээчийн ажлын ачаалал өндөр байна.

Шүүх эмнэлгийн шинжээч эмч нарын гаргасан дүгнэлтийг хохирогч, холбогдогч талын аль нэг нь хүлээн зөвшөөрөхгүй байх, прокурор эсхүл мөрдөн байцаагчийн санаачилгаар гэх мэт олон шалтгааны улмаас шинжээч эмчийн дүгнэлтийг дахин давтан бүрэлдэхүүнтэйгээр гаргах шаардлагатай болдог байна. Иймээс нэг талаас шинжээч эмч нарын ажлын ачааллыг харгалзах, нөгөө талаас бүрэлдэхүүнтэй хийгдэх шинжилгээний тоо, нөхцөл байдлыг харгалзан Шүүх эмнэлгийн шинжээч эмч нарын ажлын ачааллыг бууруулах талаар анхаарах шаардлагатай.

Эдийн засгийн шинжилгээний газар

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар батлагдсан "Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар", мөн Хууль зүй, дотоод хэргийн сайд болон Сангийн сайдын 2017 оны хамтарсан 110/137 тушаалаар баталсан "Эдийн засгийн шинжилгээ хийх журам" -ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

- Өмч хөрөнгө ашигласан, шамшигдуулсан хэрэг, төсөв зориулалтын бусаар зарцуулсан, өмч хөрөнгөтэй холбоотой албан тушаалын хэрэг, татвар төлөлттэй холбоотой хэрэг зөрчлийн холбогдолтой аудитын дүгнэлт гаргасан материалд шинжилгээ хийж дүгнэлт гаргах;

- Эдийн засгийн бусад хэрэг маргаанд шинжилгээ хийж дүгнэлт гаргах;
- Эд хөрөнгийн үнэлгээнд дүгнэлт өгөх;
- Орон тооны бус шинжээчдийн үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;

- Аймаг, нийслэлийн шүүхийн шинжилгээний албаны шинжээч нарыг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдний мэдлэг, ур чадварыг ахиулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх гэсэн чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Эдийн засгийн шинжилгээний газар нь 2017 онд 231 шинжилгээ хийсэн байна. Харин орон нутгийн хувьд нийтдээ 136 шинжилгээ хийсэн байна.

Хүснэгт 9. Эдийн засгийн шинжилгээний тоон мэдээлэл /2009-2017/

Он	Орон тоо	дүгнэлт		Шинжилгээ хийсэн объектын тоо	Орон тооны бус комисс ажиллаж байхад орон нутагт хийгдсэн шинжилгээ
		Нийт	Орон нутгаас		
2009	5	121	15	5982	20
2010	6	143	12	7893	31
2011	6	141	16	8415	25
2012	7	185	23	10958	21
2013	7	216	25	12317	18
2014	5	197	39	6425	-
2015	5	194	40	10246	-
2016	6	164	35	4533	-
2017	7	136	41	4926	-

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 110/137 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Эдийн засгийн шинжилгээ хийх журам" -ын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт "Аймаг дахь орон тооны бус комиссын бүрэлдэхүүнийг Шүүхийн шинжилгээний албаны даргын саналыг үндэслэн Аймгийн Засаг дарга 3-5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж болно." гэж заасан байсан. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны А/114, 141 тоот хамтарсан тушаалаар хүчингүй болгосон.

Иймд 2017 оноос хойш орон нутагт хийгдэх эдийн засгийн шинжилгээг Улаанбаатар хотод хийх, эсхүл Улаанбаатар хотоос тухайн орон нутагт томилолтоор очиж шинжилгээг хийх болсон. Энэ нь эдийн засгийн шинжилгээний ажлын ачааллыг хоёр дахин нэмэгдүүлэхэд хүргэжээ. Үүнээс гадна орон нутагт хийгдэж байгаа шинжилгээ нь тухайн хугацаанаас хамаарч 14-30 хоногт хийгдэх шаардлагатай боловч томилолтын зардал хүрэлцээгүйгээс эдийн засгийн шинжилгээ бүрэн хийгдэхгүй, улмаар чанаргүй хийгдэх тохиолдол гарч болзошгүй байдаг.

Тусгай шинжилгээний газар

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Тусгай шинжилгээний газар нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны "Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн бүтэц, орон тооны дээд хязгаар батлах тухай" А/42 дугаар тушаалын дагуу Биологийн шинжилгээний лаборатори, ДНХ-ийн шинжилгээний лаборатори, Бактериологийн шинжилгээний лаборатори, Химийн шинжилгээний лаборатори, Физикийн шинжилгээний лаборатори гэсэн алба хэлтэстэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тус газар нь дараахь чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Үүнд:

- Химийн бодис элементийн найрлага тогтоох, тодорхойлох шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- Физикийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- Биологийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- ДНХ-ийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- Бактериологийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- Дуу авианы харьцуулсан шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- ДНХ-ийн шаардлагатай объектоор төрөлжсөн сан бүрдүүлж ашиглах шинжилгээ хийж дүгнэлт гаргах
- Орон нутгийн шинжээчдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, тэдний мэдлэг, ур чадварыг ахиулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Тусгай шинжилгээний газрын биологийн лаборатори

Тус лабораторид өнөөгийн байдлаар 1 ахлах шинжээч, 2 шинжээч, 2 лаборант, 1 шил угаагчийн орон тоотой буюу нийт 7 орон тоотой үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү лаборатори нь улсын хэмжээнд 21 аймаг, Улаанбаатар хотын 9 дүүргийн нутаг

дэвсгэрт гарсан гэмт хэргийн эд мөрийн баримтад дүгнэлт гаргадаг байна.

Хүснэгт 10 Шинжилгээний тоо /2011 -2017/

Он	Шинжилгээний тоо	Объектын тоо	Шинжээчийн тоо	Нэг шинжээчийн хийсэн шинжилгээний тоо /дунджаар/
2011	3137	12548	3	785
2012	4265	17060	3	1465
2013	5281	21124	4	1320
2014	5060	20240	4	1265
2015	5115	20460	4	1278
2016	5148	21780	3	1716
2017	5159	21980	3	1719

Дээрх тоон үзүүлэлтээс үзэхэд 2011-2017 оны хооронд шинжилгээний объектын тоо болон нэг шинжээчид ногдож байгаа шинжилгээний тоо жил ирэх тусам өсөж, ажлын ачаалал нэмэгдэж байгааг харуулж байна. Үүнээс харахад тусгай шинжилгээний газрын биологийн лабораторийн шинжээчээр ажиллаж буй ажилтны тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Тусгай шинжилгээний газрын химийн лаборатори

Тусгай шинжилгээний газрын химийн лаборатори нь анх 2008 онд 6 орон тоотой үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл тус лабораторид ямар нэгэн орон тоо нэмэгдээгүй байна. Энэхүү лаборатори нь лабораторийн эрхлэгч 1, ахлах шинжээч шинжээч 2, лаборант 1 гэсэн орон тооны бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Химийн лаборатори нь ажил үүргийн хувьд сэжигтэн, холбогдогч нараас болон хэргийн газраас хураагдсан эд мөрийн баримт, холбогдох бусад нотлох баримтад шинжилгээ хийдэг бөгөөд сүүлийн жилүүдэд шинжилгээний тоо өсөх хандлагатай байна.

Тусгай шинжилгээний газрын хийсэн шинжилгээний тоон мэдээлэл

Хүснэгт 11

Он	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
Шинжилгээний тоо	3740	5012	5194	4747	5529	5286	5348	4398

Тусгай шинжилгээний газрын химийн лабораторийг байгуулснаас хойш орон тоо нэмээгүй боловч химийн лабораторид хийгдэж байгаа шинжилгээний тоо өсөж байгаа нь лабораторийн ажлын ачааллыг харгалзан шинжээч ажилтны орон тоог нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай болохыг харуулж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37, 39, 43 дугаар зүйлийг үнэлэхэд шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, санхүүжилт, шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг тусгасан зүйл, заалтууд нь тус хуулийн 1 дүгээр зүйлд тусгасан уг хуулийн зорилттой зарим талаар нийцээгүй байна. Тодруулбал: Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэгт шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоог тодорхойлсон боловч шүүхийн шинжилгээний байгууллагын тогтолцоо, үйл ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлсон нарийвчилсан зохицуулалт хангалтгүй байгаа нь харагдаж байна. Шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, түүний эрх, үүрэг тодорхойгүй, шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн эрх зүйн байдал тодорхой бус байна.

Хуульд шүүхийн шинжилгээний байгууллагын удирдлага, түүний бүрэн эрх тодорхой бус, шүүхийн шинжилгээний байгууллагын төсөв, санхүүжилт хангалтгүй, шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтны эдийн засаг, нийгэм, хууль зүйн, баталгааг нарийвчлан тусгаагүй зэрэг асуудал гарч байна. Үүнээс гадна шүүхийн шинжилгээний хугацаа тодорхой бус, зарим тусгай мэдлэг шаардагдах шинжилгээг хэрхэн хийх талаарх зохицуулалт хуульд тодорхой бус, шүүхийн шинжилгээний ажилтан, албан хаагчийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, мөн шинжээчийн хараат бус байдлыг хангах зэрэг шаардлагатай зохицуулалтыг хуульд нарийвчлан тусгах шаардлагатай.

Иймд дараахь асуудлуудыг Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь боломжтой байна.

Шүүхийн шинжилгээний үйл ажиллагааны хараат бус байдлын талаар

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт "шүүхийн шинжилгээ хийхэд хараат бус байх зарчмыг баримтална" гэж тусгасан. Эрүүгийн хуулийн 21.6 дугаар зүйлийн 21.6.1 дэх хэсэгт "Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчийг хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулахтай холбогдуулан өөрт нь, ойр дотны хүнд нь хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулж болохуйц баримт, мэдээлэл тараахаар сүрдүүлсэн, эсхүл ятгасан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ." гэж заасан. Өөрөөр хуулийн энэхүү заалтад "шинжээч"-ийг орхигдуулсан байдаг. Иймд тус Эрүүгийн хуулийн тус заалтад нэмэлт, өөрчлөлт оруулж, "шинжээч"-ийг нэмж тусгаж тэдгээрийг хараат бус байх,

хариуцлагатай байх зарчмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхээр байна.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлд “шинжилгээ хийх хугацаа”-нд холбогдох зохицуулалтыг тусгасан. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тогтоож байгаа хугацаа нь шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад хангалттай байж чаддаггүй гэж судалгаанд оролцогч нар хариулсан байна. Иймээс Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх хугацааг тогтооно.” гэсэн зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулж, тухайн чиглэлийн шинжилгээний хугацааг түүний онцлогоос хамааран ялгаатай байдлаар хуульд тусгах шаардлагатай. Түүнчлэн тухайн чиглэлийн шинжилгээний төрөл нэг бүрийн жишиг хугацааг тогтоох асуудлыг хуульд холбогдох сайд, агентлагийн даргын баталсан шийдвэрээр шинжилгээнээс тус тусдаа зохицуулалт хийснийг өөрчилж, тухайн шинжилгээний цар хүрээ, онцлогоос гадна байгууллагын ажлын ачаалал, шинжилгээнд ирүүлсэн объект, загвар, дээжийн бүрдэлтэй холбоотой байгаа тул түүнийг харгалзан үзэж шинжилгээний хугацааг нэгдсэн байдлаар зохицуулах буюу Засгийн газарт тусгайлан эрх олгосон заалтыг хуулийн төсөлд тусгах замаар шийдвэрлэх нь шинжилгээний хараат бус байх зарчмыг хэрэгжүүлэхэд мөн дэмжлэг болохоор байна гэж үзлээ.

Дахин шинжилгээг хийлгэхээр шинжээч томилох асуудлыг анхаарах шаардлагатай. Мөн шинжилгээ хийх бүрэлдэхүүнд орсон нарийн мэргэжлийн эмч нарыг томилох, шинжилгээ хийхэд оролцуулах харилцааг хуулиар зохицуулах, шүүхийн хүнд суртлыг арилгах, хэргийг шийдвэрлэдэг механизмыг нь боловсронгуй болгох талаар холбогдох газрууд санаачлагатай ажиллах шаардлагатай байна.

Шүүхийн шинжилгээний тогтолцооны талаар:

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэгт “Шүүхийн шинжилгээний төв байгууллага нь дэргэдээ сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны нэгжтэй **байж болно**” гэж заасан боловч энэхүү асуудал нь өнөөг хүртэл Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дэргэд эрдэм шинжилгээ, судалгааны төвийг байгуулаагүй байна.

Иймд шүүхийн шинжилгээний байгууллагын чиг үүрэгт зөвхөн шүүх шинжилгээ хийхээс гадна эрдэм шинжилгээ, судалгаа, сургалт хийх чиг үүрэг бүхий бүтцийг байгуулах замаар тус байгууллагын болон мэргэжлийн судлаачдын мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх, шинжилгээний үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулж бэхжүүлэх, чанарыг сайжруулах тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай.

Хууль сахиулахын их сургуулийн сонсогчдод хууль сахиулах байгууллагуудын тогтолцоо, чиг үүрэг, хоорондын уялдаа холбоо, аль чиглэлээр ажиллахад ямар мэдлэг

чухал болохыг ойлгуулах сургалтыг оруулах, бусад хуулийн сургуулиудад шүүх шинжилгээний чиглэлийн хичээлийг мэргэжлийн багш нараар заалгах асуудлыг анхаарах шаардлагатай.

Хууль сахиулах салбарын хэмжээнд хэрэг мөрддөг, шинжилгээг гардан хийдэг, шинжилгээ хийхэд туслах үүрэгтэй оролцдог (лаборант, туслах ажилтан, бага эмч зэрэг) хүний нөөцийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай байна. Шаардлагагүй орон тоог багасгаж шинжээчдийн орон тоонд шилжүүлэх нь зүйтэй.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Шүүхийн шинжилгээний байгууллагыг улсын төсвөөс санхүүжүүлнэ." гэж тусгасан боловч шүүхийн шинжилгээний байгууллагын батлагдсан нийт төсвийн ихэнх хувийг цалингийн зардал эзэлж, байгууллагад тоног төхөөрөмжийн шинэчлэл, хөрөнгө оруулалт хийгдээгүй нь үндсэн чиг үүргээ биелүүлэхэд хүндрэлтэй болгож байна.

Шүүхийн шинжилгээний байгууллагад хийж буй шинжилгээний 50 хувийг эзэлж байгаа хүний биед хийх шинжилгээний талаас илүү хувьд нь буюу 15 000 шинжилгээнд нарийн мэргэжлийн эмчийн оношлогоо, багаж төхөөрөмж шаардлагатай болж байгаа тул КТГ, MRI, Рентген, Тархины цахилгаан бичлэгийн төхөөрөмж, ЭХО, Зүрхний цахилгаан бичлэгийн аппарат гэх мэт багаж, тоног төхөөрөмжийг яаралтай авч ашиглах, түүн дээр ажиллах нарийн мэргэжлийн эмч нарын орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Түүнчлэн шүүх эмнэлгийн задлан шинжилгээний байр хотын төвд байрлаж байгаа нь эрүүл ахуйн шаардлагад нийцэхгүй байгаа зэрэг асуудалд цогцоор нь анхаарах шаардлагатай.

Шүүхийн шинжилгээний ажилтны эрх зүйн байдал, нийгмийн баталгааны талаар

Шүүхийн шинжилгээний хүрээлэн 2005 оноос хойш ХЗДХЯ-ны харъяа бие даасан байгууллагын хувиар үйл ажиллагаа явуулж буй шүүхийн шинжилгээ, судалгааны байгууллага болж мэргэжлийн/хими, физик, биологи гэх мэт/ шинжилгээний баг, мэргэжилтнээс бүрдсэн боловсон хүчинтэй байх хүний нөөцийн бодлого баримталж байгаа хэдий ч мэргэжлийн өндөр мэдлэгтэй, ажлын туршлагатай, шинжээч, албан хаагчдаа тогтвор суурьшилтай ажиллахгүй байгаагийн гол шалтгаан нь шинжээчийн ажлын ачаалал их, цалин бага, нийгмийн хангамж сул байгаатай холбоотой.

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлд шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан, албан хаагчийн эрх зүйн баталгааг тусгасан боловч энэ байгууллагын ажилтны ажиллах орчин нөхцөл, мөн ажлын ачаалал өндөр байгаа зэрэг тулгамдсан асуудал гарч байна. Иймээс Шүүхийн шинжилгээний байгууллагын ажилтан,

албан хаагчийн ажлын ачаалалтай дүйцүүлэн цалин хөлс, нийгмийн баталгааг олгох, мөн энэ байгууллагын ажилтны эрх зүйн баталгааг хууль сахиулах бусад байгууллагын ажилтан, албан хаагчтай адил хангах эрх зүйн баталгааг бий болгох шаардлагатай.

-----oOo-----

Ашигласан материал:

1. Legalinfo.mn
2. Mojha.gov.mn
3. Nifs.gov.mn
4. Шүүхийн шинжилгээний тухай хууль
5. Эрүүгийн хууль
6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
7. Хөрөнгийн үнэлгээний тухай хууль
8. Шүүхийн шинжилгээний байгууллага болон хууль сахиулах бусад байгууллагын ажлын уялдаа
Т.Очирбат ШШҮХ-ийн шинжилгээний бүртгэл мэдээллийн хэлтсийн дарга, дэд хурандаа ХСИС-ийн докторант 2014
9. Шүүхийн шинжилгээ Харьцуулсан судалгаа Хууль зүйн үндэсний хүрээлэн 2015
10. "Шүүхийн шинжилгээний хэрэгжилтийн үр дагаварт хийсэн тайлан" Хууль зүйн үндэсний хүрээлэн
11. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн тэргүүн дэд захирал, цагдаагийн хурандаа
Ч.Алтанхишиг: Шинжээч гаргасан дүгнэлтийнхээ төлөө хуулийн өмнө өөрөө хариуцлага хүлээх ёстой. 2018.04.18 08:04 News.mn